

Агуулга

1. Төслийн танилцуулга	2
2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	7
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
4. 2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	11
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	15
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	25
15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	26
Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим.....	5
Хүснэгт 2. Хүдэр бутлан ялгах цехийн ажиллах горим	6
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 6.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 8.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
Хүснэгт 9.Талуудад тайлагнах хуваарь	25
Зураг 1.Төслийн байршил	2
Зураг 2.Ил уурхайн одоогийн байдал	3
Зураг 3.Уурхайд нэвтэрсэн хэвтээ малталтууд болон ил уурхайн ухаш.....	3

1. Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч: “Мальфлюорит” ХХК


Улсын бүртгэлийн дугаар: 901223069

Регистрийн дугаар: 5366941

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-013348 /41.57га/

MV-013539 /49.82 га/


Төслийн байршил: Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн хойшоо 485 км, Хэнтий аймгийн Батноров сумын төвөөс баруун хойш Бэрх тосгоноос хойш 30 кмт Батноров сумын Баян багийн нутагт харьяалагдана.



Зураг 1.Төслийн байршил


Уурхайн одоогийн байдал

1980-1982 онд Бэрхийн уурхайгаас Малийн уурхайн 2-р хүдрийн биетийн зүүн хойд гарш хэсэгт ил уурхайн олборлолтын ажлыг явуулж байсан бөгөөд ил уурхайн ухаш 10-59 м гүнтэй, 130 м өргөнтэй, 260 м урттай үүссэн байдаг. Ил уурхайн ёроол +1243 м-ийн түвшинд байгаа ба ил уурхайн ёроолын өргөн 3-5 м өргөнтэй, траншейн налуу 3-4 градус байна.




Зураг 2. Ил уурхайн одоогийн байдал

Малийн жоншны ордын 2-р хүдрийн биет дэх геологийн нийт нөөц C1 болон C2 зэргээр 1899.4 мян.тн (CaF_2 захын агуулга 20% үед) бөгөөд үүнээс 1986-1988 оны хооронд +1240 м, +1265 м түвшингүүдэд нэвтэрсэн хэвтээ малталтуудаас дээш орших блокуудад олборлолт явуулан нийт 63.6 мян.тн хүдэр олборлосон байна. +1265 м-ийн түвшний хэвтээ малталт нь 300 орчим м урттай ба ил уурхайн баруун хананы +1265 түвшин дэх аюулгүйн бермээс эхэлж нэвтэрсэн байна. Харин +1240 м-ийн түвшин дэх хэвтээ малталтыг ил уурхайн амнаас баруун урагш 45 м-ийн зайд +1259 түвшингээс налуу ам нэвтэрч +1240 м түвшинд хэвтээ малталт нэвтэрсэн байна. +1240 м-ийн түвшин дэх малталтын урт 500 м орчим байна.



Зураг 3. Уурхайд нэвтэрсэн хэвтээ малталтууд болон ил уурхайн ухааш

Одоогийн байдлаар Далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 2023-2025 оны хооронд +1210 м, +1180 м, +1150 м-ийн нийт 3 түвшинд 5,114 метрийн малталт нэвтрэлтийн ажил хийж гүйцэтгээд байна.



Ашиглалтын систем: Хүдрийн биет баруун хойш $31-46^\circ$ өнцгөөр унах буюу уналын өнцөг дунджаар 400 байна. Унал дагуугаа хүдрийн биет мэшил хэлбэрийн бөгөөд зарим хэсэгтээ өргөссөн тогтоцтой. Хүдрийн биетийн зузаан ба агуулга нь маш жигд бус бөгөөд хүдрийн биетийн зузаан 2.0- 11.0 м буюу +890 м-ээс +1040 м түвшинд дунджаар 2 м, +1040 м-ээс +1290 м түвшинд дунджаар 7 м зузаантай байна. Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөлүүдийг харгалзан 2 м-ээс бага зузаантай хүдэр буюу +1040 м-ээс түвшнээс доош орших хүдрийг хүдэр хоршоолох ашиглалтын системээр, 2 м-ээс дээш зузаантай буюу +1040 м-ийн түвшнээс дээш орших хүдрийг дэд давхраар нураах ашиглалтын системээр тус тус ашиглахаар сонголоо. Хүдрийг хоршоолон ашиглах ашиглалтын систем: Энэ систем нь бэлтгэл болон огтлолын ажлын хэмжээ, модон материалын зарцуулалт бага, нураагдсан хүдрийн бэлэн нөөцтэй байдаг тул үйлдвэрлэлийн хүчин чадлыг тогтмол байлгах боломжтой. Хүдрийг зөөх, олборлолтын орон зайг бэхлэх ажлын хэмжээ хамгийн бага, өрөмдлөг тэсэлгээний ажлын үр ашиг өндөр байдаг зэрэг давуу талтай. ОХУ-д судал хэлбэрийн ордын 40 гаруй хувийг хүдэр хоршоолох системээр ашигладаг

бөгөөд АНУ, Канад, БНАСУ, Герман, Болгар болон бусад орнуудад мөн өргөн хэрэглэж байна. Манай улсын ихэнх далд уурхайнуудад энэ системийг ашигладаг.

Мөргөцгийн бүтэц: Хүдрийн биетийн суналын дагуу байрлах бөгөөд олборлолтын талбай буюу мөргөцгийн өргөн нь хүдрийн биетийн зузаантай ижил, урт нь 50 м, өндөр нь 25 м байна.

Бэлтгэл ажил ба нэвтрэлт: Хүдрийн биетийн доогуур штрек нэвтэрнэ. Хүдрийн биетэд нэвтэрсэн штрекээс дээш блокийн восстающий, цонх малталт, холбоос малталт, хүдэр буулгуур нэвтэрнэ.

Өрөмдлөг ба тэсэлгээ: Блокод холбоос малталтууд нэвтэрч блокийг ашиглалтад бэлдсэний дараа мөргөцгийн тааз руу босоо чиглэлтэй шпур өрөмдөн шпурын цэнэгийн аргаар нураана. Өрөмдлөгийн ажлыг гар перфератораар гүйцэтгэх ба шпуруудийг 2.0 м урттай догол болгон өрөмдөж дараа нь тэсэлнэ. Тэсэлгээний дараа агааржуулалт хийж орчныг ажилд бэлдэнэ.

Агааржуулалт: Цэвэр агаар нь квершлаг, штрекээр дамжин олборлолтын мөргөцөгт хүрнэ. Бохир агаар нь ногоо жигүүрийн цонх малталт, восстающийгаар дамжин агаар агааржуулалтын штрекээр дамжин гадагшилна. Тэсэлгээний дараах агааржуулалтыг богино хугацаанд гүйцэтгэхийн тулд хэсэгчилсэн агааржуулалт ажиллуулна.

Хүдэр гаргалт: Мөргөцгөөс хүдрийг тэслэн нураасны дараа 25-35 хувийг нь доош хүдэр буулгуураар дамжуулан буулгана. Хүдрийн биетийн уналын өнцөг дунджаар 40 градус тул ихэнх хүдэр өөрийн жингээр доош унахгүй тул хүдрийг скреперээр татаж хүдэр буулгуурт унагаана. Тогтворжилтгүй хэсэгт хамгаалалт бэхэлгээ хийх шаардлагатай. Хүдэр буулгуур дахь нөөцийг бүрэн буулгасны дараа хүдрийг бүрэн буулгаж олборлоно.

2026 Онд уурхайн ажиллах горим, календарь төлөвлөлт: Малийн хайлуур жоншны далд уурхайн газрын доор ажилчид нь хоногт 3 ээлжтэй, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг харин газрын дээрх ажилчид нь хоногт 2 ээлжтэй, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байхаар Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсон байна.

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Газрын доор	Газрын дээр
1	Хуанлийн хоног	Хоног	275	275
2	Баяр ёслол тооцсон хоног	Хоног	15	15
3	Завар үйлчилгээ тооцсон хоног	Хоног	24	9
4	Жилд ажиллах хоног	хоног	236	251
5	Хоногийн ажлын горим	ээлж	3	2
6	Ээлжийн хугацаа	Цаг	8	12
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	Цаг	24	24
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	5664	6024
Ээлжийн цаг ашиглал				
9	Наряд авах	Мин	20	20
10	Хоолны цаг	Мин	60	60

11	Ээлж хүлээлцэх	Мин	20	20
12	Бусад	Мин	10	10
13	Ээлжин дэх сул зогсолт	Мин	110	110
14	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	Мин	8	9
15	Ээлжийн цэвэр ажиллах цаг	Цаг	6.17	7.17
16	Хоногт ажиллах цаг	Цаг	18.5	14.3
17	Ээлжийн цаг ашиглалт	Цаг	77%	80%
18	Жилд ажиллах цэвэр ажлын цаг	Цаг/жил	4370	4820

Далд уурхайн хүчин чадал: Далд уурхайд ажиллах тоног төхөөрөмж, тэдгээрийн бүтээл, уул техникийн нөхцөл, зэрэгт үндэслэн техник эдийн засгийн үндэслэлд хүчин чадлыг 150.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар тооцоолсон. Далд уурхайн төлөвлөлтөөр 2026 онд 38.81% дундаж агуулга бүхий 172,440 тн хүдэр олборлолтод өртөхөөр байна.

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

2026 онд баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийн ажил болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил, туршилтын ажил хийгдэх бөгөөд “Мальфлюорит” ХХК нь өөрийн эзэмшлийн Маль хайлуур жоншны ордыг компанийнхаа санхүүгийн өнөөгийн байдал болон ордын дэд бүтцийн хөгжлөөс алсдагдсан байдалд тулгуурлан тус ордод хамгийн үр ашигтай зардал багатай ашиглалтын технологийг нэвтрүүлэх, ордоос олборлосон хүдрийг зардал багатай технологиор боловсруулж жоншны баяжмал үйлдвэрлэн БНХАУ, ОХУ-ын зах зээлд нийлүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 2.Хүдэр бутлан ялгах цехийн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	2021 он
1	Төслийн нийт хуанлийн хоног	хоног	365
2	Урсгал засвар	хоног	12
3	Баяр ёслол	хоног	15
4	Жилд ажиллах бодит хоног	хоног	338
5	Өдрийн хуанлийн цаг	цаг	24
6	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
7	Өдрийн ээлж	ээлж	1
8	Цаг ашиглалт	%	85
9	Өдөрт ажиллах бодит цаг	цаг	10
10	Жилд ажиллах бодит цаг	цаг	3,448
11	Цагийн хүчин чадал	тн/цаг	23.0
12	Хоногийн хүчин чадал	тн/хоног	234.4
13	Жилийн хүчин чадал	тн/жил	79,236

2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Төсөл хэрэгжих орчны тухай: Тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Дагуур Монголын хээрийн их муж, Дагуурын уулын хээрийн муж, Улз голын сав газрын тойрогт багтана. Хэнтий аймгийн Батноров сумын зүүн хойд хэсэгт орших төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн Хойд Хэрлэн-Өмнөд Улзын хагарлын мужийн завсарын бүсэд оршино. Уг дүүрэг нь далайн түвшинээс дээш 1250-1450 м өргөгдсөн намхан уул толгодорхог гадаргуутай юм. Талбайн усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөрөгийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн дүүргийн тектоник эвдрэлийн чигтэй давхацдаг. Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын Хангайн хөрсний их мужийн Хэнтийн мужид багтана. Тус мужийн төв хэсэгт хамгийн өндөр өргөгдсөн /үнэмлэхүй өндөр нь 2400-2750м/ Хэнтийн гол нуруу орших бөгөөд түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээт талд шилжинэ. Төсөл хэрэгжих талбайн орчинд хар хүрэн, сайргархаг хар хүрэн, алювийн бараан хөрс зонхилно. Цаг уур, уур амьсгалын мужлалтаар чийглэгдүү хүйтэвтэр зунтай бүсийн, хахир өвөлтэй мужид хамаарна. Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их муж, Дорнод Азийн Улз-Хэрлэнгийн тойрогт хамаарагдана

Уур амьсгал: Энэ бүсэд хур тундас жилд 250-300мм ордог. Нийт хур тундасны 70-80% нь дулааны улирал буюу зуны 3 сард ордог байна. Энд өвөлдөө 11.20-03.20 хүртэл цасан бүрхүүлтэй байдаг. Жилийн дундаж агаарын хэм 0- -2 0C байгаа боловч агаарын температурыг ултралын байдлаар авч үзвэл темдратурын хэлбэлзэл харьцангуй эрс тэс байдалдтай буюу өвөлдөө -430C хүртэл хүйтэрч зундаа +400C хүртэл халдаг. Энэ бүс нутагт өвлийн улиралд нэн хүйтэн өдөр буюу -300C-ээс хүйтэн өдөр 30-40 өдөр, зуны улиралд нэн халуун өдөр буюу +300C-ээ халуун өдөр 20-30 өдөр тохиолддог байна. Энэ бүсэд зонхилох салхи нь баруун болон баруун урд зүгээс салхилах бөгөөд бусад зүгээс харилцан адилгүй бага хүчээр салхилдаг байна. Энд хүчтэй буюу 15м/с-ээс илүү хурдтай салхитай өдөр 10 өдөр байдаг бана мөн энэ бүсэд шороон шуурга жилийн 10-30 өдөрт, цасан шуурга 3-5 өдөрт салхилдаг.

Гадаргын ус: Тус төслийн талбай нь Номхон далайн ай савд, Улз голын сав газарт хамаарагдана. Гидрогеологийн мужлалаар улирлын дунд зэрэг тэжээлтэй, Монголын Дорнод хэсгийн дэд мужид оршино. Гадаргын болон газрын доорхи ус нь номхон далайн ай савд хамаарагдах ба голын сүлжээний нягтшил харьцангуй бага буюу 0.05км/км² , гол мөрний нийлбэр урсац нь 2-3л/с км² , хур борооны үерийн хамгийн их урсац 10-30мм, шар усны үерийн хамгийн их урсац 4-20мм бөгөөд хаврын шар ус, зуны хур борооны усаар үерлэдэг шинж чанартай. Голын тэжээлийн хувьд газрын доорх ус 20%, цасны ус 25%, хур борооны ус 55% байна. Хур тунадасны жилийн нийлбэр нь 300-400мм боловч нийлбэр ууршилт нь 200-250мм-т хүрдэг байна. Зуны улиралд усны гадаргаас уурших ууршилт 900-1100мм ба энэ нь

зарим жижиг гол, нуурууд ширгэх шалтгаан болдог. Тухайн нутаг дэвсгэр дэх гадаргын усны нийт нөөц 1.51км^2 , үүнээс ашиглаж болох 0.15км^2 , газрын доорхи усны 0.30км^2 нь ул хөрсний ус бөгөөд ашиглаж болох боломжит нөөц нь 0.20км^2 юм. Аймгийн хэмжээнд авч үзвэл усны ашиглах боломжит нөөц нь 1096 мян м³ /жил, 1км^2 талбайд ногдох усны нөөц нь 8.87м^3 /жил, 1 хүнд ногдох усны нөөц 16.63м^3 /жил байна. Төслийн талбайн гадаргын усны томоохон илэрц нь Улз гол юм. Голын үндсэн тэжээл нь хурын ус тул 5 болон 6-р сард голын ус эрс татарч хамгийн нам түвшинд буухад усны зарцуулга ойролцоогоор 2-3 м/сек орчим буюу түүнээс ч бага болно.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын Хангайн хөрсний их мужийн Хэнтийн мужид багтана. Тус мужийн төв хэсэгт хамгийн өндөр өргөгдсөн /үнэмлэхүй өндөр нь 2400-2750м/ Хэнтийн гол нуруу орших бөгөөд түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээт талд шилжинэ. Төсөл хэрэгжих талбайн орчинд хар хүрэн, сайргархаг хар хүрэн, аллювийн бараан хөрс зонхилно.

Ургамлан нөмрөг: Монгол орны физик газарзүйн мужлалаар Дагуур-Монголын хээрийн их муж, Дагуурын уулын хээрийн муж, Улз голын сав газрын тойрогт багтана. Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их муж, Дорнод Азийн Улз-Хэрлэнгийн тойрогт хамаарагдана. Уулын хөндий, энгэр хажуугийн хормой дагасан уулын хар шороон ба хар хүрэн хөрстэй газрын алаг өвс-улалж-жижиг дэгнүүлт үетэнт, гэхдээ голчлон биелэг өвс зонхилно. Эдгээрт Крыловын Хялгана, Сунагар Биелэг, Агь, Хялгасан Дэвхэргийн цагаан, Гмелиний Шарилж, Бариулт Бүйлээс зэрэг ургамлын бүлгэмдэл орно.

Амьтны аймаг: Төслийн талбай орчимд газар сүүгээр бойжигч амьтдын зүйлийн бүрдэлд 6 баг 11 овог 22 төрөл 27 зүйл хөхтөн тарсан байна. Шувууны бүлгэмдэлд 11 багийн 43 зүйл шувууг бүртгэв. Эдгээр шувуу нь суурин, өндөглөж зусдаг, дайрч өнгөрдөг, тохиолдлын шинжтэй, ховор элбэг зэргээр янз бүрийн байдалтай байгаа бол хоёр нутагтан мөлхөгчдийн анги төлөөлөгчдөөс монгол бах, могой гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг 4 зүйл хүйтэн цуст амьтад тохиолдоод байна. Үүнээс зарим хөхтөн тухайлбал Саарал чоно, шар үнэг, хярс, дорго, мануул зэрэг хөхтөн нь Адаг орчим хэвийн, Бор-Өндөр орчим цөөн нутагшсан.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

“Маль” хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бүрэлдэхүүн тус бүрээр дараах байдлаар тодорхойлов.

3.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Барилга байгууламж барих, уурхайн босоо гол амны нэвтрэлтийн ажил, олборлолтын үеийн хүерийн овоолго үүсгэх, зам талбай засах хөрс хуулах, хөрс, хүдэр тээвэрлэх гэх мэт үйл ажиллагааны үед тоосжилт үүснэ.
- Уурхай дахь тээврийн хэрэгсэл болон автомашины хөдөлгүүрийн дутуу шаталтын хий нь агаар орчныг хорт хийгээр бохирдуулж болзошгүй.
- Барилга байгууламж барих, уурхайн олборлолтоос үүдэн чичиргээ доргио, дуу шуугианы бохирдлыг үүсгэж болзошгүй.
- Тоосжилт, хорт хийн ялгаралт, тэсэлгээнээс үүдэх дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны айл өрхийн амгалан тайван байдал алдагдаж, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

3.2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Тэсэлгээ явуулах, гадаад овоолго үүсгэх, тээвэрлэлтийн зам засах, холбогдох барилга байгууламж барих зэргээр газрын гадарга, хэвлийд нөлөөлнө.
- Уурхайн оффис, ахуйн барилга байгууламж, дотоод гадаад тээвэрлэлтийн зам зэрэг уул уурхайн нөлөөгөөр газрын гадаргын өнгөн хэсэг эвдрэлд өртөнө.
- Төслийн ТЭЗҮ-д тусгагдаагүй талбайд суваг, шуудуу татах, нүх ухах, барилга байгууламж нэмэлтээр барих, далан байгуулах зэргээр газрын гадарга, хэвлий эвдрэх талбай нэмэгдэж болзошгүй.
- Хүнд, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрс суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.
- Нефтийн гаралтай материал, тэсрэх бодисын асгаралт, шүүрэлт мөн үйлдвэрлэлийн болон, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүснэ.

3.3. Ургамлан бүрхэвч, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь уурхайн олборлолтын үйл ажиллагаа, овоолго үүсгэх, дотоод болон гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцор, төслийн бүхий л барилга байгууламжууд, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, хүн, техникийн нөлөөгөөр ургамлан нөмрөг устах буюу доройтолд орно.

3.4. Усан орчин, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Ордын хайгуулын өрөмдлөгийн явцад уст үе тэмдэглэгдээгүй тул уг жоншны ордыг агуулагч хурдас усжилт багатай гэж үзэж болох хэдий ч тухайн дүүрэгт хийсэн гидрогеологийн судалгаагаар 3-н уст үе тэмдэглэгдсэн байдаг тул уурхайн ашиглалтын үед түр зуурын харьцангуй өндөр хэмжээтэй орох ус хагарал, ан цавын систем хөндөгдсөн үед гарч болох талтай юм.
- Уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр гүний ус бохирдож болзошгүй.

3.5. Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Хайлуур жоншны орд орчмын амьтдын амьдрах орчин, экологид олборлолтын машин техникийн хөдөлгөөн, дуу чимээ, барилга байгууламжийн байршуулалт генераторын дуу чимээ, ашигт малтмалын зөөвөрлөлт, тээвэрлэлт, уурхайн тэсэлгээнээс үүсэх дуу чимээ, доржилт ихээхэн нөлөө үзүүлнэ.
- Техникүүдийн шатахуун болон тосны үнэр зэрэг нь техногенийн шинжтэй ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэгээс эдгээр амьтад дайжих замаар байршил нутгаа өөрчлөх, үүрлэж төллөдөг газруудаа өөрчлөх, байнгын стресст орох, идэш тэжээлээ эрж олох зэрэг амьдралын олон үйлажиллагаанд нь өөрчлөлт орно.

3.6. Нийгэм эдийн засагт учруулах нөлөөлөл

- Уурхайн үйл ажиллагаанаас бий болох дуу чимээ, шороо тоос, хүн, машин техникийн хөдөлгөнөөс болж орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдал алдагдаж болзошгүй.
- Бэлчээрийн хомсдол үүсэх.
- Орон нутгийн ард иргэд төсөлтэй холбоотой янз бүрийн санал, гомдол, эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй.
- Төслийн татвар хураамжаар орон нутгийн орлого нэмэгдэх бөгөөд үүний үр дүнд тухайн орон нутгийн нийгмийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт болно.
- Уурхайн үйл ажиллагаа эхэлснээр ажлын байр нэмэгдэж, малчид болон орон нутгийн хувиараа бизнес эрхлэгчид хамтран ажиллах боломжтой.

4. 2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, компаний байгаль орчны бодлогын зорилгод нийцүүлэн төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг боломжит бага утганд тогтмол барих, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах нь энэхүү төлөвлөгөөний гол зорилго болно.

Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 0.89 га талбайд 800 ширхэг мод тарьж ургуулах, арчлах, нутагшуулах, цаашид тарьж ургуулах модны тоог нэмэх зорилго тавин ажиллахаар төлөвлөж байна.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхайн ажилчдын хотхоноос уурхайн налуу ам хүртэл уурхайн ажилчид машинтай зорчих үед тоосжилт үүсэх	Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг шүүрлийн усаар услах.	Уурхайн олборлолтын үед	м ²	1 м ² талбайг 2л усаар	1	500 000	6-9-р сар	MNS 4585:2016 MNS 3384-82 MNS 12.055- 9
2	Уурхайн дотоод тээвэрлэлтэнд явж буй машинуудаас тоосжилт үүсэх	Тээвэрлэлтийн үед тоос шороо босохоос сэргийлж мөн олон салаа зам гаргахаас сэргийлж замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд	га	MV-013348 /41.57га/ MV-013539 /49.82 га/	2	1 000 000	7-р сар	
Хөрсөн бүрхэвч									
3	Уурхайн эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох, талхлагдах, ургамлан нөмрөг устана.	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар ажилчид, жолооч операторуудад сургалт орох	Уурхайд ашиглах машин, механизмуудад	ширхэг	-	2	500 000	6 сар 9 сар	MNS 4969:2000
4	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй	Машин механизмийн засвар үйлчилгээ	Уурхайд ашиглах машин, механизмуудад	м2	MV-013348 /41.57га/ MV-	300	Үйл ажиллагааны зардалд орно.	6 сар	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	хийх талбайд хатуу хучилт хийх			013539 /49.82 га/				
Усан орчин									
	Шатахуун, тос тосолгооны материал болон ахуйн хатуу шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх ус бохирдохоос сэргийлэх	ШТС болон хог хаягдлын цэгийг бетонжуулах, мөн нийт ажилчдад сургалт зааварчилгаа зохион байгуулах	Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд		MV-013348 /41.57га/ MV-013539 /49.82 га/	1	1 000 000	7 сар	
Амьтны аймаг, ургамлан нөмрөг									
5	Олон хүний хөл хөдөлгөөн, машин техникийн холхилтоос ургамлан бүрхэвч талхагдана.	Тогтсон нэг маршрутаар ажилчдыг зорчуулах, ан амьтан агнахгүй байх талаар нийт ажилчдад сургалт орох	Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд	га	MV-013348 /41.57га/ MV-013539 /49.82га/	-	500 000	Уурхайн ашиглалтын бүх цаг үед	-
Нийт зардал							3 500 000		

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 онд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан авч үлдэх, тэдгээрийн амьдрах орчин нөхцөл байдлыг сайжруулах ажлыг төсөл хэрэгжих талбайгаас өөр талбайд бүрэлдүүлэх	Хэнтий аймгийн Батноров сумын Баян багийн нутагт байрлах Цог-Өндөр нэртэй орхигдсон карьерт техникийн нөхөн сэргээлт хийх	га, м ³	0.22	8 000 000	8 000 000	8-р сард	БОНБНУ-ний тухай хуулийн 3.1.11-д зааснаар “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах”

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйлийн 41,1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан.

Хуулийн дээрх зүйл заалтын дагуу “Мальфлюорит” ХХК-ийн Малийн уурхайн тусгай зөвшөөрөлтөй талбай болон нөлөөллийн бүст газар эзэмших эрхийн гэрчилгээтэй айл өрх байхгүй байна. Иймд 2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй.

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2023 оны 05-р сард хийгдсэн Археологи, Палеонтологийн судалгааны ажлын тайлангийн үр дүнгээр түүх, соёлын ямар нэгэн олдвор болон ургамал амьтны үлдэгдэл илрээгүй болно. 2026 онд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөөгүй.

10.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аадар бороо. Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээллэх хэрэгтэй. Үерийн гамшгаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар компанийн ажилтан нэг бүрд ухуулга, зааварчилгаа өгөх. Үерийн ус орж ирж болзошгүй Тэсрэх бодисын агуулахын хашааг битүүмжлэх арга хэмжээ авах /шуудай, элсний нөөц бий болгох/

Халдварт өвчин: Хүний болон байгалийн голомтот өвчин болох тарваган тахал, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар томилолтоор үүрэг гүйцэтгэдэг тэсэлгээний багт зориулсан сургалт зохион байгуулах. Халдварт өвчний дэгдэлт гарсан тохиолдолд үүрэг гүйцэтгэх компанийн бие бүрэлдэхүүнээс бүлэг томилж, хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах. Хүн, малын гоц халдварт өвчнөөс сэргийлж, дархлаажуулалтын вакцинд ажилчдыг хамруулах ажлыг зохион байгуулах, мал бүхий иргэдийн малыг бүрэн хамруулах. Уурхайн эмч өдөр бүрийн жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавих ариутгалын уусмалаар хангах

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмждээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагааж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчидын аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Аадар бороо. Дэд бүтцийн байгууламж нурж сүйдэх, уурхай үерлэх, дэд бүтцийн байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах зэрэг эрсдэлтэй.	Хур бороо, үер уснаас хамгаалах суваг, шуудууг сэргээн засварлах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1	500 000	500 000	5-9-р сард	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр
2	Шороон шуурга. Үзэгдэх орчин хязгаарлагдсанаар аваар, осол гарах нөхцөл бүрдэнэ. Хүчтэй шороон шуурга салхи нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлнө.	Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ мэдээлэл, бүх алба нэгжүүдэд шуурхай хүргэх, хяналтын арга хэмжээ авах, өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1	Үйл ажиллагаа ны зардалд орсон		Төслийн бүх хугацаанд	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр
3	Халдварт өвчин. Төсөл хэрэгжиж буй бүс нутагт олон нийтийг хамарсан тахал, халдварт өвчин гарснаар хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулна, хөдөлмөрийн чадвар түр хугацаанд алдах эрсдэлтэй.	Уурхайн ажилчдад хангалттай хүрэхүйц нэг удаагийн бээлий, ариутгалын хэрэгсэл, эм тариаг бүрдүүлэх. Хэнтий аймгийн ЗООНОЗ-ын өвчин судлалын төвөөр уурхайн бүсийн барилга байгууламжид ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	2	1 000 000	1 000 000	Төслийн бүх хугацаанд	Эрүүл мэндийн тухай хууль
4	Гал түймэр. Нефтийн бүтээгдэхүүний асгаралтын улмаас хөрсний бохирдол үүсгэх, хүний санамсар болгоомжгүй байдлаас үүдэн гал түймэр гарах	Гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байдалд байлгах, удирдах ажилтан тогтмол хяналт тавьж илэрсэн дутагдлыг биечлэн засах, холбогдох арга хэмжээг авч ажиллана. Нийт ажилчдыг онцгой байдалд бэлэн байх, хариу арга авах сургалт зааварчилгаанд хамруулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1	1 200 000	1 200 000	Төслийн бүх хугацаанд	Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт зардал						2 700 000		

11.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Уурхайн орчинд хог хаягдлын ангилах ялгалтын савнуудыг нэмж байрлуулах.		250 000	4	1 000 000	6-8-р сард	Хог хаягдлын тухай хууль
		Дахин ашиглагдахгүй хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт төвлрүүлэх, орон нутагтай хамтран ажиллах	тоо	200 000	3	2 400 000	6, 8, 10-р сар	
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан дугуй, аккумулятор зэргийг зориулалтын талбайд хуримтлуулах	тоо	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Тухай бүрт	
3	Шингэн хог хаягдал.	Машинаас гарсан хаягдал тос масло болон бусад аюултай бодисуудыг зориулалтын талбайд хуримтлуулах, тусгай зөвшөөрөл бүхий компанид нийлүүлэх	тн	700 000	-	700 000	9-р сард	
Нийт зардал						3 200 000		

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсонболзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрт эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх юм.

“Мальфлюорит” ХХК-ийн “Мааль”, “Маль”-ийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах бөгөөд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах зорилгоор жил бүр хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлдэг.

2026 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар							
1	Тоос нийт (PM10, PM2.5), CO ₂ , NO ₂ , SO ₂ , H ₂ S	Уурхайн гол ам, ажилчдын хотхон 1, 2 дээр нийт 3 цэгт хэмжилт хийлгэнэ. (нэг цэгт 20 минут, автомат анализатораар хэмжилт хийхээр тооцсон)	7, 9 сард	Жилд 2 удаа	25 000	150 000	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
Хөрсөн бүрхэвч							
2	Агрохими болон механик бүрэлдэхүүн	Уурхайн ажилчдын кемп 1, 2 Хог хаягдлын цэг орчим Ажилдчын жорлон Тэсэлгээний агуулахын ойр орчим, үйлдвэрийн барилга орчим	7, 9 сард	Жилд 2 удаа	Агрохими шинжилгээ 56 900 төгрөг	683 000	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин							
3	Бактериологи Химийн ерөнхий шинжилгээ	Унд ахуйн ус Шүүрлийн ус	7, 9 сард	Жилд 2 удаа	Химийн ерөнхий шинжилгээ – 65 000	260 000	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4		Томилолтын зардал+Шатахууны зардал	500 000	
	Нийт		1 593 000	

13.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Уурхайн ажиллагсдын удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулагдана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага, заавар дүрмийг ажиллагсдад эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах.
- Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үндэсний хөтөлбөр”, “Аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм”, “Ашигт малтмалын ордыг далд аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.
- “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, эрх зүйн актууд, тогтоол журам шийдвэр, стандарт шаардлага, зөвлөмжийг судалж баяжуулан мөрдөх.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх ажлыг доорхи удирдлага зохион байгуулалтын системийн дагуу биелүүлж ажиллах нь чухал гэж үзлээ.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-013348, MV-013539 тоот ашиглалтын тусгай зөвшрөөлийн талбайд орших “Мааль, Маль” нэртэй хайлуур жоншны уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдэд газар дээр нь танилцуулна.	1 000 000	9 дүгээр сард	Уурхайн дарга болон Байгаль орчны мэргэжилтэн	2026 онд хийгдэх ажлын ерөнхий төлөвлөгөөг ЗДТГ-н мэргэжилтэнд танилцуулах
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	2 000 000	9 дүгээр сар	Мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулна.	Халдварт өвчний үед авах арга хэмжээ, үйлдвэрийн осол эрсдлээс хамгаалах арга хэмжээ, Байгаль орчны нөхөн сэргээлт
3	2026 онд байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Хэнтий аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх	-	11 дүгээр сарын 1 ний дотор	Байгаль орчны мэргэжилтэн	2026 онд хийгдсэн ажлуудын биелэлтийн тайланг хүргүүлнэ.
	Нийт	3 000 000			

14.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8.Талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Батноров сумын нутгийн оршин суугчдад	Пресентацаар	Далд уурхайн үл ажиллагаа	9-10 сард	2 000 000	Байгаль орчны мэргэжилтэн, Уурхайн дарга	Сумын соёлын төв
	Нийт				2 000 000		

15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	3 500 000
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	8 000 000
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2 700 000
4	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний зардал	3 200 000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 593 000
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	3 000 000
7	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	2 000 000
Нийт		23 993 000

Тайлбар:

Батлагдсан БОННУ тайланд 2026 онд Баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдсөн байгаа. Хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалан 2026 онд баяжуулах үйлдвэрийн барилга бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан. Баяжуулах үйлдвэртэй холбоотой зардлууд хасагдаад 2026 оны БОМТ-ын зардал 23,993,000 төгрөг болсон.

9.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн зардал

Хүснэгт 176. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /2025-2029/

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	5 жилийн БОМТ-ны зардлын төлөвлөлт				
		2025	2026	2027	2028	2029
Агаарын чанар						
Хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх,	5.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
Тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг 20 км/цагаар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах.	-	-	-	-	-	-
Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	5.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
Агаарын хяналт шинжилгээг тогтмол хийх	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон					
Нийт зардал, сая.төг	10.0	2.0	2.0	2.0	2.0	2.0
Ус						
Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх.	-	-	-	-	-	-
Шатахуун, тос тосолгооны материал болон ахуйн хатуу шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх ус бохирдохоос сэргийлэх	-	-	-	-	-	-
Ус ашигласны төлбөрийг цаг тухайд төлөх	-	-	-	-	-	-
Усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах, хяналт тавих	-	-	-	-	-	-
Усны хяналт шинжилгээг тогтмол хийх	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон					
Нийт зардал, сая.төг	-	-	-	-	-	-
Амьтан						
Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархац судалгаа хийлгэх	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон					
Лицензийн талбайн бүс рүү зэрлэг амьтад орохыг хязгаарлах, хяналт тавих	-					
Өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах.	2.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Нэн ховор, ховор амьтныг хамгаалах.	-	-	-	-	-	-
Нийт зардал, сая.төг	2.5					
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг						
Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	1.0	0.2	0.2	0.2	0.2	0.2
Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	1.0	0.5	0.5	-	-	-
Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	8.0	1.6	1.6	1.6	1.6	1.6
Нийт зардал, сая.төг	10.00	2.30	2.30	1.80	1.80	1.80

Нийт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	22.50	6.80	4.80	4.30	4.30	4.30
Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ						
Хөв цөөрөм байгуулах, биотехникийн арга хэмжээ	74.8	14.9	14.9	14.9	14.9	14.9
Осол аюулын эрсдэлийн менежмент						
Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	2.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	1.0	0.2	0.2	0.2	0.2	0.2
Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох, Автомашинуудыг кабиныг битүүмжлэл сайтай болгох	-	-	-	-	-	-
Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох	-	0	0	0	0	0
Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	0	0	0	0	0
Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	2.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрд байрлуулах	-	-	-	-	-	-
Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургаалтанд хамруулах, Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах		0	0	0	0	0
Жолооч бүрийг даатгалд хамруулах		Үйл ажиллагааны зардалд орсон				
Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулах		0	0	0	0	0
Нийт зардал, сая.төг	6.0	1.2	1.2	1.2	1.2	1.2
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө						
Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	2.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах	-	0	0	0	0	0
Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг сумын төвд 2-догч түүхий эд авах цэгт тушаах	-	0	0	-	-	-
Дугуй, модны хаягдлыг дахин ашиглах, орон нутгийн хэрэгцээнд өгөх	-	0	0	0	0	0
Автомашин сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	-	0	0	0	0	0
Цаас, цаасны хаягдлыг цаас боловсруулах үйлдвэрт тушаах	-	0	0	0	0	0
Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох	-	0	0	0	0	0
Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	2.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах	-	-	-	-	-	-
Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулах		-	-	-	-	-
Ахуйн бохир шингэн хаягдлыг битүүмжлэл сайтай ёмкост хуримтлуулан бохир соруулах машинаар соруулах	1.5	0.3	0.3	0.3	0.3	0.3

Бохир ус хуримтлуулах сав буюу ёмкосыг нэвчилт шүүрэлт явагдахааргүй битүүмжлэл сайтай хийх	-	-	-	-	-	-
Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх.	-	-	-	-	-	-
Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	-	-	-	-	-	-
Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	-	-	-	-	-	-
Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумын ТҮК-тай гэрээ байгуулан зайлуулах	-	-	-	-	-	-
Хог хаягдлын бүртгэл хөтлөх, зургаар баримтжуулах	-	-	-	-	-	-
Нийт зардал, сая.төг	6.5	1.3	1.3	1.3	1.3	1.3
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ						
Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	-	0.0	0.0	0.0	0.0	0.0
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ы ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	30.0	10.0	0.0	10.0	0.0	10.0
Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургаалтанд хамруулж байх	-	-	-	-	-	-
Байгаль орчны үйл ажиллагаа, нөхөн сэргээлттэй танилцах хүсэлтэй иргэд, албан байгууллага, төлөөлөгчдөд уурхайн үйл ажиллагааг танилцуулах	2.0	0.4	0.4	0.4	0.4	0.4
Нийт ажилчдад байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт хийх	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр мод тарих	-	Нөхөн сэргээлтийн зардалд оров				
Нийт зардал, сая.төг	32.00	10.40	0.40	10.40	0.40	10.40
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20.5	4.1	4.1	4.1	4.1	4.1
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	5.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
БОМТ-ний НИЙТ ЗАРДАЛ, сая.төг	168.8	37.2	28.1	37.7	27.7	37.7
Нөхөн сэргээлтийн зардал						
Хаалт, нөхөн сэргээлтийн зардал	940.0	-	-	-	-	-
НИЙТ ЗАРДАЛ, сая.төг	1108.8	37.2	28.1	37.7	27.7	37.7